

БАРУУН-УРТ СУМЫН 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО:

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:Тайлант сарын байдлаар Тамгын газраас 111 бичиг явж, 169 бичиг ирсэн байна.Үүнд:

Хариутай бичиг-17, хугацаандаа явсан-4, хугацаа болоогүй-3 байна.

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрт танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, барагдуулалтад хяналт тавьж ажиллалаа.

Тус Тамгын газар нь албан хэргээ хос бичгээр хөтөлж хэвшсэн.

Байгууллагын даргаас гаргасан 142 шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчилгүй шийдвэр гаргаж хэвшсэн.Үүнд: -Захирамж А/73 -Захирамж Б/11 -Тушаал А/13 - Тушаал Б/45 байна.

“Малын А” дансны лавлагаа авах хүсэлт гаргасан 40 иргэнд лавлагаа гарган өгсөн.

Багийн Засаг даргаас 464 иргэнд тодорхойлолт гаргаж үйлчилсэн.

Төрийн үйлчилгээний оператор 940 иргэнд төрийн цахим үйлчилгээний лавлагаа гаргаснаас төлбөртэй үйлчилгээ 112, төлбөргүй 822 байна.Үүнд:

- 1.Нийгмийн датгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээлэл -235
2. Иргэний үнэмлэхний лавлагаа-171
3. Шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх лавлагаа-84
4. Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-67
5. Иргэнд олгох тодорхойлолт-67
6. Зээлийн бүрэн мэдээлэл-48
7. Эрүүл мэндийн даатагал-42
8. Үл хөдлөх хөрөнгө жагсаалтаар -32
9. Оршин суугаа хаягийн лавлагаа-29
10. Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх-29
11. Төрсний бүртгэлийн лавлагаа-27
12. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх-25
13. Жолоочийн лавлагаа-22
14. Хүүхдийн мөнгөнд хамрагдсан эсэх -14
15. Гэрэлсний бүртгэлийн лавлагаа-8
16. Өндөр настны тэтгэвэр тогтоололын хуудас -6
17. Жолооны үнэмлэх захилга -6
18. Шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх ААН-6
19. Газрын кадастрийн зураг-5
20. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх-4
21. Авто тээврийн хэрэгсэл эзэмших эрхийн лавлагаа-1
22. Гэрлээгүй бүртгэлийн лавлагаа /англи/ -2
23. Мал тоологын лавлагаа-1
24. Нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардалатай эсэх -1
25. Эрүүл мэндийн цаг авах-1
26. Тэтгэвэр авах эрх үүсээгүй лаюлагаа -1
27. Хуулийн этгээд нэр баталгаажуулах -1
28. Хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр тогтоололтын хуудас-1
29. Хуулийн этгээд дэлгэрэнгүй лавлагаа-1

- 30. Хуулийн этгээд үүсгэн байгуулагч -1
 - 31. Гэрэлсний бүртгэлийн лавлагаа /англи/-1
 - 32. Үндэсний гадаад паспортны бүртгэлийн хуудас-1
- Нийт 32 төрлийн 940 лавлагааг 940 иргэнд гаргаж өгсөн.

Тамгын газраас хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг олон нийтэд мэдээлэх зорилгоор орон нутгийн BBS тв, Сүхбаатарын өнгө сонин, Sb ingo сайт хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 10 удаа мэдээлэл нийтэлсэн.

Багийн Засаг дарга нар айл өрхөөр явж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан.

Алдарт эхийн одонгийн болзол хангасан 121 эхийн материалыг хүлээн авч, аймгийн Засаг даргын Тамгын газарт уламжилсан.

2022 оны хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу түр хадгалах 120 баримтуудыг хүлээн авч архивласан.

Тамгын газрын харьяа төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад аймгийн архивын газрын ажилтан Б.Эрдэнэноминтой хамтран архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт, мэдээлэл өгч ажилласан.

Хууль эрх зүйн чиглэлээр:

2023 онд шинээр батлагдсан Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийг байгууллагын мэдээллийн цагаар нийт албан хаагчдад мэдээлж, холбогдох мэргэжилтэнд хэрэгжилтэд зохион байгуулах талаар тусгайлан зөвлөгөө өглөө. Мөн согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилж ажилласан.

1 дүгээр улирлын байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 2 удаа хугацаанд нь тайлагнаж үр дүнг тооцож ажилласан. Үүнд:

01 дүгээр сарын 05-ны байдлаар:

- 8 хуулийн 31 заалт
- УИХ-ын 2 тогтоолын 2 заалт
- УИХБХ-ны 2 тогтоолын 2 заалт
- Ерөнийлөгчийн 6 зарлиг 8 заалт
- ҮАБ-ын 2 зөвлөмжийн 2 заалт
- ҮАБЗХ-ны 1 тэмдэглэл 2 заалт
- ЗГ-ын 5 тогтоол 5 заалт
- ЗГ-ын 2 хуралдааны тэмдэглэл 2 заалт
- ЗГ-ын 1 албан даалгаврын 1 заалт

03 дугаар сарын 09-ний байдлаар:

- ЗГ-ын 2 тогтоол 2 заалт
- ЗГ-ын 2 хуралдааны тэмдэглэл 2 заалт
- ЗГ-ын 1 албан даалгаврын 1 заалт байна.

Аймгийн ХШҮ-ний цахим сангийн ашиглалтыг хариуцан зохион байгуулж, тайлан, мэдээг хугацаанд нь чанартай тайлагнахад хяналт тавьж ажиллаж байна. 1 дүгээр улирлын байдлаар 5 удаа хяналт хийж, холбогдох албан хаагчдад зөвлөгөө, чиглэл өгч ажилласан.

-Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлт-73.3%

-ЗГҮАХ-ийн хэрэгжилт-46.0%

-Аймгийн хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл-80.0%

-Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт-30.0% тус тус тайлагнасан байна.

Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөөг гарган Тамгын газрын даргаар батлуулан ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу 1 дүгээр улирлын байдлаар дараах чиглэлийн дагуу хяналт хийхээр удирдамж гарган батлуулаад байна.Үүнд:

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад авсан байдал

-Өргөдөл гомдол барагдуулалт, шийдвэрлэсэн байдал

-Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу байгууллагын архивт баримтаа хугацаанд нь тушаасан байдал.

Хяналтыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

1 дүгээр улирлын байдлаар аймгийн Засаг даргын 2 албан даалгаврыг хяналтад авч, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган батлуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. 01 дүгээр албан даалгаврын биелэлт 70% хэрэгжилттэй байна. 08 тоот албан даалгавар тайлагнах хугацаа болоогүй байна.Албан даалгавар, хэрэгжүүлэх төлөвлөгөөг мэдээллийн цагаар албан хаагчдад мэдээлж байгаа бөгөөд хариуцсан тасаг нэгжийг үүрэгжүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Сургууль, цэцэрлэгийн сарын ажлын тайлантай хэлэлцэж, санал дүгнэлтийг бодлого хариуцсан мэргэжилтэнд өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай 2023 оны 02 дугаар сарын 10-нд 6 бүлэг 64 арга хэмжээ н ийлүүлэхээр гэрээ байгуулсан. Гэрээг байгууллагын мэдээллийн цагаар албан хаагчдад танилцуулан, өөрт хамаарах заалт арга хэмжээг хяналт авч, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг анхааруулж ажилласан.Цахим файлыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд байршуулсан. Мөн албан хаагч бүрд биечлэн сануулж ажилласан.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хүрээнд эрх зүйн хөтөч бэлтгэн, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажилд аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-тэй гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөөд байна. Хөтөчөөр ажиллах 3 иргэний судалгааг

гарган аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-т хүргүүлсэн. Судалгааг үндэслэн сумын хэмжээнд ажиллах 3 хөтөчтэй гэрээ байгуулаад байна.Эрх зүйн хөтөч нарыг 04 дүгээр сардаа багтаан платформ сургалтад хамруулахаар төлөвлөсөн.

Тамгын газрын эрх зүйн ажлын төлөвлөгөөг гарган Тамгын газрын даргаар батлуулаад байна. Төлөвлөгөөг байгууллагын дотоод зөвлөгөөнөөр нийт албан хаагчдад танилцуулан, хамтран ажиллах санал солилцсон.Цаашид хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.

Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг байгууллагын дотоод зөвлөгөөнөөд нийт албан хаагчдад, төсөвт байгууллагын зөвлөгөөнөөр сургууль, цэцэрлэг, ОНӨААТҮГазруудыг захирал, эрхлэгч, дарга нарт, тус сумын хэмжээний сэтгэл зүй, сэтгэл судлаач нарт хөтөлбөр, түүний зорилт, бодлого, чиглэлийг тус тус танилцуулсан. Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан, Засаг даргаар батлуулан ажиллаж байна.

Сумын АТТ-өөг 5 бүлэг 21 заалтаар боловсруулан Тамгын газрын даргаар батлуулан ажилласан. Мөн харьяа төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарын гэрээнд уг арга хэмжээг тусгай захиалж нийлүүлсэн. Цаашид уг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож ажиллана.

Төрсний бүртгэл-68, эцэг эх тогтоосны бүртгэл-2, нэр өөрчилсний бүртгэл-1, Иргэний үнэмлэхний хугацаа дуусч авсан-59, шинээр олгосон иргэний үнэмлэх-27, Аймаг, хотоос шилжин ирсэн-21, хот доторх шилжилт хөдөлгөөн-50, сум дүүрэгт шилжин ирсэн-12,баг хооронд шилжсэн-31, гэрлэлт цуцлалт-6, Үрчлэлт-1, овог нэр өөрчилсөн-1, нас баралт-8 тус тус бүртгэн үйлчилсэн байна.

САНХҮҮ, ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хөрөнгө оруулалтын чиглэлээр: 2023 оны 1,3 дугаар багийн тоглоомын талбайн засварын ажлын зураг төсөвийн ажилд гэрээ байгуулан ажилласан. Мөн соён гэгээрүүлэх ажлын 1,4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн шилжүүлээд байна.

Ухаалаг тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг 54,0 сая төгрөгөөр зарлан зохион байгуулж тендер нээх шатандаа явагдаж байна. Жаргалан хотхоны гадна талбайн тохижилт Саруул хотхоны гадна талбайн тохижилтын ажлын магадлалын дүгнэлт хийх шатанд явагдаж байна.

Байгууллагын мэдээллийн самбар зэрэг 8-10 хэрэгсэлүүд тогтмол ашиглан мэдээлэлийг тухай бүр хүргэн ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт гүйцэтгэлийн талаарх мэдээлэл, постер, урилга, зар, цаг үеийн мэдээлэл, нэвтрүүлэг, шинэчилэгдсэн хууль, дүрэм журам заавар зэрэг 19 удаагийн мэдээллийг байгууллагын үндсэн пэйж хуудас болон холбогдох группд мэдээлж ажилласан. Байгууллагын вэб сайтад орон нутгийн хөгжлийн сангийн линкийг байршуулсан.Үүнд:

Baruun-urt.su.gov.mn вэб сайт,

Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын Засаг даргын Тамгын газар пэйж хуудас,

Баруун-Урт сумын 9-н багийн цахим сайт,

Орон нутгийн хөгжлийн сангийн ажилтанууд пэйж

Удирдлага мэдээллийн систем

Tender.gov.mn -Shilendans.gov.mn

Орон нутгийн BBS телевиз,

Зууны мэдээ сонин,

Ухаалаг тоног төхөөрөмж нийлүүлэх А/42, Худалдааны гудамжны тохижилт А/50 Саруул хотхоны гадна талбайн тохижилт А/54, Жаргалан хотхоны гадна талбайн тохижилт А/55, Явган зам нэмэгдүүлэх ажил А/53, Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа А/51 тоот захирамжаар ажлын хэсгийг тус тус байгуулаад байна.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 12 дугаар сарын 29-ний өдрийн 15/12 тоот тогтоолоор 2022 оны хөрөнгийг бүртгэлжүүлсэн. Нийт 16 нэр төрлийн ажил 410,1 сая төгрөгийн хөрөнгийг хурлын тогтоолоор баталгаажуулсан. Нэмэлт 2 ажил 40,0 сая төгрөгийг тамгын газрын тайланд, орон нутгийн хөгжлийн сангийн тайланд 256,0 сая төгрөгийг хөрөнгийг бүртгэлжүүлсэн.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтад хамрагдах 4 албан хаагчийн нэрсийн жагсаалтыг 3/31 тоот албан бичгээр орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн. Шалгалтад 3 албан хаагч тэнцсэн.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ сайт болон зууны мэдээ сонинд Нийтийн эзэмшлийн орон сууцнуудийн дээвэр засвар / 7 дугаар баг, 27 в байр, одкон хотхон 1, 2 дугаар байр / ажлын урилгыг мэдээлж тус тендер 02 дугаар сарын 03-ний өдөр нээж тендерт 7 компани оролцож тендерт нар сар газар ХХК шалгарч 167,1 сая төгрөгөөр гэрээ байгуулж ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр болон сар бүрийн мэдээллийг 100 хувь бүрэн байршуулсан. Шинэ системийг бүрэн ашиглаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээ мэдээлэл, шторк, зар, ирсэн бичиг зэргийг тогтмол 5 нэр төрлийн 10 мэдээлэл байршуулсан. Цахим монгол үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем /ERP/-ийг мэдээ мэдээлэл солилцох, авах зориулалтаар, ер чат татаж цаг ашиглалтыг 100 хувь бүртгүүлэн ажиллаж байна.

Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн жилийн ажлын тайланг 3/1255, 3/1256, 3/1257 тоот албан бичгээр Хөрөнгө оруулалт төлөвлөлт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүү төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлэн ажилласан.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван тавдугаар хурлын 15/12 тоот тогтоолоор баталсан хөрөнгийн жагсаалтыг 3/1254 тоот, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 3/3 тоот албан бичгээр орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн. Тоглоомын талбайн засварын ажлын тендерт 2 компани оролцож тендерт Хайлааст гарам ХХК 57,526.5 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан. Шалгараагүй Наранбулаг сүх баатар принтинг ХХК шалгараагүй мэдэгдэл хүргүүлсэн. Нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр засвар / 5 дугаар багийн 10-н айл/ ажлын тендерт 2 компани материал ирүүлж тендерт “Молцог элс ХХК” 31,453.4 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан. Шалгараагүй Хайлааст гарам ХХК компанид мэдэгдэл хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан болон хоршоо хөгжүүлэх сангийн анхан шатны баримтыг 2 дугаар сарын 13 нд төрийн аудитын газарт хүргүүлсэн. Төрийн аудитаас ирүүлсэн ОНХС-гийн дэлгэрэнгүй судалгааг бөглөж 02 дугаар сарын 10-нд цахим 2023 оны 02 дугаар сарын 16-ний өдөр 3/80 тоот албан бичгээр 16 байгууллагат тендер зарлан зохион байгуулах албан бичиг хүргүүлсэн.

Үдийн цай хөтөлбөр, хоол хүнсний тендерийг 12 байгууллага зарлан зохион байгуулаад байна. Үдийн цай хөтөлбөр, хоол хүнсний тендер зарлах ажиллагааг цахим системээр 2 удаа хяналт тавин ажилласан.

Төсөв, төрийн сангийн чиглэлээр:3 дугаар сарын 17-ны байдлаар нийт 177 төлбөрийн хүсэлт ирсэнээс амжилтгүй-52, амжилттай-125 гүйлгээ буюу 639,959,322.22 төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.125 амжилттай хийгдсэн гүйлгээний баталгаажсан төлбөрийн хүсэлт болон хавсралт материалуудын цаасан болон цахим архив үүсгэсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн бодлого:

Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны А/48 дугаар захирамжаар Малын сэг зэм устгах, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг Аймгийн төвөөс 5 км радиус бүхий газарт бэлчээр цэвэрлэгээ, ариутгалыг 2023 оны 03-р сарын 20-ны өдрөөс эхлэн Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазартай хамтран хийж гүйцэтгэж байна. Цэвэрлэгээнд нийт 1 ковш, 1 ачааны машин, 1 суудлын машин 3 жолооч, 2 туслах ажилтан, 2 мэргэжилтэн ажилласан. Тус ажлын хүрээнд 800 малын сэг зэм түүж устгаж, 2000 м2 талбайг ариутгаж халдваргүйтгэлийг хийсэн.Том малын зүй бус хорогдол болон төлийн хорогдлын мэдээг цаг тухайд нь 9-н багийн ажлын албанаас авч программд шивж ажилласан. Баруун-урт сумын хэмжээнд 533734 мал байгаагаас тэмээ-2, адуу-183, үхэр-211, хонь-845, ямаа-872, хорогдоод байна.

Худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйлчилгээний стандарт бараа бүтээгдэхүүний чанар стандарт, тохижилт үйлчилгээнд хяналт тавих зөвлөн туслах зорилгоор Цагаан сар нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу 26 аж ахуйн нэгжээр хяналт шалгалтын ажил зохион байгууллаа. Хяналт хийсэн аж ахуй нэгжүүдэд илэрсэн

чанар аюулгүй байдлын хадгалалт хугацаа дууссан бүтээгдэхүүнийг хураан авч холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өглөө.

Хоршоодыг чадавжуулах зорилгоор АНУ-аас санхүүжилттай БЭСТ хөтөлбөр, Канадын засгийн газраас дэмжлэгтэй МЭРИТ төсөл мөн аймгийн хоршоологчдын холбоотой хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж 44 иргэн, аж ахуй нэгжийг хамруулж зөвлөн туслах чиглэл өгч ажиллалаа. Тус сургалтын үр дүнд оёдолчид нэгдэн нэгдсэн хоршоо байгуулахаар боллоо.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 14 хоршоо байгаагаас идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 2 хоршоо байна. Түмэн цагаан ноос хоршоо, Алтан цацал хоршоодууд байна. Мэдээллийг шинэчлэн Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн Б.Баттуяатай хамтран хоршоодын үйл ажиллагааг чадавжуулах тал дээр анхаарч ажиллан сургалт зөвлөгөө, арга зүйн зөвлөгөөг 5 хоршоонд өгөөд байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор сар бүрийн төлөлтийг хянан зээлээ төлөөгүй иргэдтэй холбогдон зээлийн эргэн төлөлтөө хийх тал дээр сануулж чанаргүй хугацаа хэтэрсэн 3 иргэнд шүүхэд материалыг шилжүүлэх сануулга өгч ажиллалаа. Цаашид ЖДҮ газраас зөвлөмж зөвлөгөө өгсөн дагуу прокурорт материалыг шилжүүлэхээр болсон. Монгол банкны мэдээллийн сангийн цахим программд иргэдийн зээлийг тогтмол оруулж байна.

Боловсролын чиглэлээр:

“Соёлын бүтээл сар”-ын жилийн ажлын төлөвлөгөөг гарган батлууллаа. 1 дүгээр сар төлөвлөлтийн ажлын хүрээнд төлөвлөгөөг хугацаанд нь батлуулсан. 2 дугаар сар Монгол хүн-Монгол хүүхэд сарын хүрээнд уламжлал цагаан сарын баярын ёс уламжлалыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах зорилгоор “Амар байна уу” нэвтрүүлгийн орон нутгийн BBS телевиз, харьяа төсөвт байгууллагуудтайгаа хамтран хийлээ. Нийт 16 байгууллагын 300 гаран ажилтан албан хаагч хүүхэд багачууд хамрагдсан. Нэвтрүүлгийг 5300 иргэн үзсэн хандалттай байна.

Сумын хүүхэд хөгжил хамгааллын төлөвлөгөөг 3 бүлэг 24 заалттайгаар боловсруулж. Хүүхэд хөгжил хамгааллын нээлтийг 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хийлээ.

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хангаж, журамт үүргээ ухамсарлан хэрэгжүүлэх, хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн болон сургуулийн үйл явцад хүүхдийн бүтээлч оролцоог хангах, тэдний дуу хоолойг сонсож, орон нутгийн түвшинд үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхэд зорилгоор “ОРОЛЦЪЁ, ХӨГЖЬЕ-2023” хүүхдийн чуулганыг 400 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Чуулганы дүнд хүүхдээс гарсан санал санаачлагын бодлого хөтөлбөртөө тусган шийдвэрлэх явдал юм.



Сумын Засаг даргын тамгын газрын дэргэдэх орон тооны бус Монгол хэлний зөвлөлийн 2023 оны хийх ажлын төлөвлөгөөг 2 бүлэг 15 заалттай гарган батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Харьяа байгууллагуудын албан хаагчдын монгол хэл бичгийн сургалт хийгдэж эхэлсэн.

Холбон зуучлалаар 30 кейс ирснээс илрүүлэлт 4 кейс, хаасан 4 кейс байна.

Өөрийн харьяаны 20 байгууллагыг эцэг эхийн зөвлөл, хүүхэд хамгааллын бодлоготой болгох чиглэл өгч ажилласан. Сумын Засаг даргын тамгын газар нь хүүхэд хамгааллын бодлоготой болж тамгын газрын даргаар батлуулсан.

2 дугаар Бүрэн дунд сургууль улсын төрөлжсөн олимпиадын II даваа 12 төрлийн хичээлийн 43 ангиллаар болж өнгөрсөн ба нийт 599 багш, сурагч оролцлоо. 2 дугаар сургууль алтан медаль 10, мөнгөн медаль 8, хүрэл медаль 5 хүртэж багийн амжилтаар "Олимпиадын манлайлагч сургууль"-аар шалгарлаа.

БШУГ-аас зохион байгуулсан “Эерэг хандлага” сургалтанд 386 багш ажилтан хамрагдаж дипломоо гардан авлаа.

Алсын хараа 2050 сургалтанд 132 багш, ажилтан хамрагдаж батламжаа авсан.

Ээлжит хичээлийн чанарыг сайжруулах, багш нарын заах арга зүй ур чадварыг дээшлүүлэх, зөвлөн туслахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бага ангийн 9 багшийн ээлжит хичээлд сууж зөвлөгөө өгч хамтран ажиллалаа. Монгол хэлний 7, математик 1, хүн байгаль 1 хичээл заагдсан.

Багш Б.Бямбаагийн хүсэлтээр 7-р ангиудын Иргэний боловсрол хичээл дээр “Ураг удмаа мэдь” сургалт зохион байгууллаа. Сургалтын зорилго, зорилтын хүрээнд сурагчид ураг удмын талаарх мэдээлэлтэй болох, зураглал хийх, ургийн бичиг хөтлөх зэрэг мэдээллүүдийг өгч 14 хоногийн дараа сургалтанд хамрагдвал зохих хэдэн сурагч “Ураг удмаа мэдэж ургийн бичиг үйлдсэн зэрэгт хяналт тавьж ажиллалаа.

Пи тооны өдөрлөгийн хүрээнд Дунд ангийн сурагчдын дунд *Алтан хонх* тэмцээн, ахлах ангийн сурагчид, эцэг эх, асран хамгаалагч, багш нарын дунд *Чанга шивнээ* тэмцээнүүдийг зохион явууллаа.

Сургуулийн номын сангийн дэргэдэх “Оюунлаг ирээдүй” клубын энэ удаагийн хэлэлцүүлэгт С.Отгонцэцэг багштай 8б анги хамт олон амжилттай оролцлоо. Хэлэлцүүлэгт тус ангийн сурагчид Өглөөний уншлага үндэсний хөтөлбөрт хамрагдаж уншсан номын тэмдэглэл, номын хэлэлцүүлэгээ клубын сурагчидтай харилцан ярилцлаа. Үүний үр: дүнд сурагчид ном унших дадалтай болсон төдийгүй сурагчдын хэл ярианы баялаг сайжирч өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирч байна.

“Уран жиргээ-2023” наадмын I шатыг сургууль дээрээ амжилттай зохион байгууллаа. Уралдааныг 3 насны ангилалаар явуулсан ба уралдаанд 50 гаруй сурагч оролцож авьяас билгээ уралдууллаа. Уралдааны шүүгчээр дуу хөгжмийн багш М.Гэрэлтуяа, монгол хэл уран зохиолын багш Б.Солонго, нийгмийн ажилтан Г.Биндэръяачулуу нар ажилласан.

Сэтгэх чадварын дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сэтгэн бодох чадвартай сурагчдыг нээн илрүүлэх зорилгоор сэтгэх чадварын олимпиадын 1-ийн давааг амжилттай зохион явуулж нийт 21 эцэг эх, 17 багш, 150 суралцагч нар хамрагдан оролцлоо.

Хувилбарт сургалтын 11 хүүхдэд даалгаврын сан, багц хүргэн ажилласаар байна. 1 багц хэрэглэгдэхүүнд 6 чиглэлийн 13 хэрэглэгдэхүүнийг багтаасан.

“Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд багш ажилчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж байна.

Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан ЭРЧИМ ХҮЧ, ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ багаас багш нарын дунд нээлттэй сургалт үйл ажиллагааг зохион байгууллаа.

Байгууллагын дотоод хяналтын баг, ёс зүйн зөвлөл, хүүхэд хамгааллын баг, эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгууллаа.

Тус сумын харьяа 11 цэцэрлэг нь хөдөлмөрийн гэрээг шинэчилж, дотоод журмыг хэлэлцэн багш ажилчдад танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулж ажиллалаа.

Байгууллагын багш ажилчдын дунд “сонсоё, ярилцъя, шийдвэрлэе” ажлын байрны сургалт, хэлэлцүүлэг зөвлөгөөн зохион байгуулж 7 санал санаачлагыг гарган зөвлөн тусалж ажиллаа.

Хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах зорилгын хүрээнд эцэг эхчүүдэд зориулсан "Урилгат хичээл" нээлттэй үйл ажиллагааг 5 бүлгийн дунд зохион байгууллаа.

Ажилчид номын сантай болж, өрөөндөө номоо унших боломж бүрдсэн.

Дэлхийн усны өдрийг угтан Тогтвортой хөгжлийн 6 дугаар зорилтын хүрээнд нээлттэй сургалт, үйл ажиллагааг багш амжилттай хамтран зохион байгуулж мэдээлэл хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр:

-Гепатитгүй Монгол төсөлд хамрагдаагүй үлдсэн иргэдийн 2600 иргэний нэрсийн жагсаалтыг гарган багийн ажлын албаар дамжуулан оршин суугаа хаягийг тодруулах ажлыг зохион байгуулсан. -Иргэдийг илрүүлэг үзлэгт хамруулах ажлыг идэхижүүлэх зорилгоор Иргэдэд үйлчлэх төвийн байранд 58, явуулаар 180 иргэнээс В,С вирусын шинжилгээг авч АНЭ-ийн лаброторид явуулсан байна. эрт илрүүлэг үзлэг шинжилгээ 50%

4 дүгээр сургуулийн 1-6 дугаар ангийн сурагчдад хүүхдийн өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулсан ба нийт 865 хүүхэд үзлэгт хамрагдахаас 755 / 87,2%-тай хамрагдсан.үүнээс 239/31,6% эрүүл,шүдний цоорол 365/48,3%,Харааны хямралтай 21/2,8%,ТИК 33/4,4%, байна. -Сумын хэмжээнд хүүхдийн эрт илрүүлэг үзлэг 90 хувийн хэрэгжилттэй явж байна. -Артерийн даралт-2500,чихрийн шижин-1700,хөх-1400,умаин хүзүү-300,

-Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20,0 сая төгрөг батлагдаж Энэрэлт ачтан ӨЭМТ-д татлагын ор, Энхлэн ачтан ӨЭМТ-д хаш чулуун ор тус бүр олгож Уламжлалт эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн -Уламжлалт эмчилгээнд 450 иргэн хамрагдсан.

Швейцарын Хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны хамтарсан санхүүжилттэй МАСАМ-2 төслийг Гэр Бүлийн Сайн Сайхны нийгэмлэг“Хараа Хүрэхүй” ТББ хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Сайн эмнэлэг-Сэтгэлд нийцсэн үйлчилгээ аргачлал боловсруулах сургалтад өрхийн эрүүл мэндийн төвийн дарга ,нийгмийн ажилтан нарыг хамруулж,аргачлалын дагуу Энэрэлт аятан өрхийн эрүүл мэндийн төвд материаллаг,засаглал ,сэтгэл зүйн орчинд хөндлөнгийн үнэлгээ хийсэн ба сэтгэлзүйн орчин-68%,засаглалын орчин 75,4% материаллаг орчин 70,3%-тай тус тус үнэлэгдсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж асаргаа шинээр тогтоолгох 7, асаргаа сунгах 24, асран хамгаалагч солих 1, хүнсний эрхийн бичиг үйлчилгээнд 1 өрхийн 2 иргэн, ОНОТХҮйлчилгээний төсөл хөтөлбөрт 7 бүлгийн төслийн 40 иргэнийг хамруулаад байна. Шинэ төрсөн хүүхэд-31, цалинтай эхийн тэтгэмжинд-39, жирэмсэн эхийн тэтгэмжинд -30, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт шинээр орж байгаа болон сунгагдсан-14, утасны хөнгөлөлтөнд 2, ахмад настны хөнгөлөлтөнд 44 ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 8 иргэнийг тус тус бүртгэн нөхөн олголтыг бүрэн хийж гүйцэтгэсэн.Хүүхдийн мөнгөтэй холбоотой биеэр ирсэн 54, утсаар 3, цахимаар 14 иргэнд зөвөлгөө мэдээлэл хүргэн ажиллалаа.

Засаг даргын А/63 тоот захирамжаар залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг шинэчлэн зохион байгуулсан, 2023 оны 03 сарын 23 нд зөвлөлийн хурлыг зохион байгуулж төлөвлөгөөг боловсруулан батлаалууна.

-Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг хугацаанд хийж хүргүүлсэн.

Харилцан хүндэтгэе аянд нэгдэж төлөвлөгөөг гарган батлуулж, эрэгжилийг ханган ажиллаж байна. Аяныг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд стенд, постер зурагт хуудас хийж цахим орчинд байршуулсан.

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр “Янзган хүрээ” хүүхдийн өрөөний нээлтийг хийж, байгууллагын 49 албан хаагчийн хүүхдүүдийг дархлаажуулсан.



Албан хаагчдын хүүхдүүдийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, цахим орчноос хөндийрүүлэх зорилгоор 2 байран дээр орчин үеийн хүүхдүүдийн унших дуртай, сэтгэхүй хөгжүүлэх 48ш номнуудаар баяжилт хийж байршууллаа.

Хүүхдийн хөгжлийн буланг тохижуулах зорилгоор "НЭГ АЛБАН ХААГЧ-НЭГ ТОГЛООМ" аяныг 2 дугаар сарын 8-наас 3 дугаар сарын 17-ны өдөр хүртэл өрнүүлж нийт 24 албан хаагч оролцож, ширхэг зөөлөн болон модон тоглоомын дэмжлэг үзүүлж хүүхдийн хөгжлийг дэмжих аянд дэмжлэг үзүүлсэн.

Багийн ахмадын зөвлөл, Аймгийн цагдаагийн газрын ахлах мэргэжилтэн Б. Арунтуяатай нартай хамтран “Ханьдаа асуудал биш Аз жаргал бэлэглэж амьдраарай” уриалгыг дэвшүүлж олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэлээ. Аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 2 ахмад настанд ахмадын зөвлөл болон ИНХ дарга нартай хамтран эргэлт хийлээ.

Ахмадын хорооноос зохион байгуулсан найрал дууны тэмцээнд багийн 30 ахмадыг хамруулж, МУ-ын СТА А. Баярхүүгээр найруулуулан амжилттай оролцлоо. Багийн ахмадын зөвлөлийн дарга М.Саруул АНУ-д аялах болсонтой холбогдуулан багийн ажлын алба, ахмадын зөвлөлийн гишүүд, багийн ИНХ дарга, сумын иргэдийн хурлын төлөөлөгч Э.Мягмардорж нар хүндэтгэл үзүүллээ. Ахмадын зөвлөлийн 7 гишүүн, мөн багийн ИНХ дарга, багийн Засаг дарга нар сар бүр 10000 төгрөгийн хуримтлал үүсгэн, ахмадуудаа дэмжин ажиллаж байна.

Сар шинийн баярыг тохиолдуулан УИХ гишүүн Б. Батсуурь, Н.Ганибал нар 2 дугаар сарын 19-ны өдөр Баруун-Урт сумын ахмадуудтай битүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Тус битүүлэгт 2 дугаар багийн 35 ахмадыг хамруулж ажиллалаа.

Дэд бүтэц, газар зохион байгуулалтын чиглэлээр:

ОНХСангийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт сумын гэр хорооллын иргэдийг зөөврийн болон шугамын усан сангаар тогтмол үйлчлүүлэх мөн хуучин усан санг ухаалаг системтэй болгох ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 21 усан санг ажиллуулан өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа бөгөөд 15 шугамын болон зөөврийн усан санг ухаалаг системд холбосон. 2023 онд 5 ширхэг усан санг нэмж ухаалаг системд холбох, шинээр 1 усан сангийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг зохион байгуулан техникийн нөхцлийг боловсруулан тендер зарлаад байна.

7 дугаар багийн нутаг дэвсгэр худалдааны гудамжийг тохижуулах ажлыг 2023 оны төсөвт тусган зураг төсвийг боловсруулах ажлыг Батсүндэрэл ХХКомпанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус зураг төсвийн эскиз хийгдсэн ба магадлалаар оруулахаар мэргэжлийн байгууллагад хүргүүлээд байна. тус ажлын зураг төсөв гармагц тендер зарлан гүйцэтгэгч компанийг шалгаруулан тус ажлыг гүйцэтгүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.


Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Худалдааны гудамжний тохижилтын ажил, Саруул хотхон болон Жаргалант хотхоны гадна тохижилтын ажлын зураг, 9 дүгээр багийн хяналтын камер суурилуулах ажлын зураг төсөв, 1,3 дугаар багийн тоглоомын талбайн зураг төсвийн ажлуудыг мэргэжлийн компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлэн ажиллаж байна.

Аймгийн газар зохион байгуулалтын хугацаа дуусаж газар зохион байгуулах төлөвлөгөөг дахин боловсруулах ажлын тендерт газар дэлхий компани шалгаран төлөвлөгөөний судалгааны ажлын талаар аймаг сумдын удирдлагууд нартай хамтран 3 өдрийн сургалтын хийж танилцуулсан. Мөн сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тодотгох ажлыг бэлтгэн дүгээр сарын сумын ИТХ-аар танилцуулахаар бэлтгээд байна.


Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөөнд тусгагдсан нийт 5 иргэний газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 17 иргэнд газар эзэмшүүлэх ажлыг сумын Засаг даргын захирамжаар эрх үүсгэн гэрээ байгуулан, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байуулж байна.

Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дээврийн аваарын гарц /чардак/, орц, подваль, хонгилд орж хоноглох, байшингийн дээвэр, чардак дээд давхаруудаар өсвөр насны хүүхэд, залуучууд олноор цугларч, дээвэр дээр гарч суух, тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэх, агсам согтуу тавьж иргэд, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах үйлдлүүд гарч байна. Үүнтэй холбогдуулан өсвөр насны хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах үүднээс нийтийн эзэмшлийн орон сууцны дээврийн аваарын гарц, эвдэж сүйтгэсэн чардакны эвдрэлийг засварлах, дээд давхарын хаалганд цоож хийж, онгорхой цоорхойг хавтангаар бөглөж, битүүмжлэн хамгаалалт, таглах, татуурга цүү хийж засварлах ажлуудыг хийж гүйцэтгэж ажиллалаа. Үүнд:

Даймонд хотхоны 6 орцонд аваарын гарцны халганд бш цоож хийж битүүмжилсэн.



Одкон хотхоны 4-н байрны дээврийн аваарын гарцыг засварлаж, таглах, онгорхой гарцанд рам зангидан гагнаж таг хийн, битүүмжлэх ажлыг хийлээ.







Одкон хотхоны 1-р байрны дээврийн аваарын гарцанд хаалга хийж, цоож цуургатай болгон битүүмжиллээ.



Цайрт хотхон, Саруул хотхоны 4 дээврийн гарцыг засварлаж, цоожлон битүүмжиллээ.



Эмнэлэгийн 38 айл, Авидын ногоон байрны дээврийн гарцны бариул цоож хийж, гарцыг битүүмжиллээ.



Дөрвөлж хотхоны 4-н байрны аваарын гарцыг цоожлож, дээврийн эвдрэлийг засварлав.



Залуус хотхон, Ганга хотхон зэрэг 5 байрны дээврийн аваарын гарцанд цоож хийж битүүмжиллээ.



Цэлмэг хотхоны 3 байрны дээврийн гарцанд 3ш цоож хийж засварлалаа.



МХГ-ын 16 айлын орон сууц, 8 айлын орон сууцны 2 байрны гарцанд цоож цуурга хийлээ.



Цагдаагийн-12 айлын орон сууцны онгорхой байсан дээврийн аваарын гарцанд хаалга хийж битүүмжлэв.




Ягаан-24 айлын орон сууцны дээд чардакны хогыг цэвэрлэж, таг хийж битүүмжлэх,



Ногоон хотхон, Саруул хотхоны дээд давхаруудын гарцны хаалгыг засварлан, таглаж, цоож хийн засварлах, битүүмжлэн дарж хадах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



60 айлын орон сууцны подвалын хаалга эвдэрч унасан байдалтай, цоож цүү цуурга байхгүй байсныг засварлаж, хаалганд нугас хийж, суурилуулан битүүмжиллээ.



Нийтийн эзэмшлийн орон сууцны 10 хотхон 53 байрны орцуудаар үзлэг шалгалтыг хийж, орцны дээврийн аваарын гарцыг цоожлох, гарц онгорхой, хаалга байхгүй орцны хаалгын засах, шинээр хаалга хийж, цоож, цүү хийх, татуурга хийх, гинжилж татах, цоож зүүж, битүүмжлэх зэрэг засварлах ажлыг гүйцэтгэлээ.

Хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд:

Айл өрх, аж ахуй нэгж байгууллагын ахуйн хэрэглээний хог хаягдлыг 2-р сард хуваарийн дагуу тогтмол тээвэрлэж хогийн нэгдсэн цэгт устгаж булшилсан.



Нийтийн эзэмшлийн 12 авто зогсоол 47500м² явган хүний зам, 246000м² авто зам, 12000м² үерийн даланг хуваарийн дагуу тогтмол цэвэрлэж нийт тонн орчим хогийг хогийн нэгдсэн цэгт хүргэж ажилласан.






Золбин нохой устгах ажлыг 7 хоног бүрийн даваа, лхагва, баасан гаригт зохион байгуулдаг. 2023 оны 3-р сарын байдлаар 16 золбин нохой устгалаа.



“Аймгийн төвөөс мал гаргах ажлын хүрээнд өдөр бүр малыг хотын төвөөс гаргах ажлыг зохион байгуулж хотын төвд орж ирсэн малыг байгууллагын мал түр хаших хашаанд хаших, гаргах зэрэг ажлыг өдөр тутамдаа тогтмол зохион байгуулж байна. Энэ сард давхардсан тоогоор 18 тооны үхэр байгууллагын мал түр хаших хашаанд хашигдсан. 100 гаруй тооны үхэр, 20 гаруй тооны адуу нийт 120 тооны малыг аймгийн ногоон бүсээс хөөж гаргасан.



Ундрах супермаркет өөрсдийн хураасан дахин ашиглах боломжтой 312 кг багцлагч гялгар уутыг тушаалаа.



Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хөтөлбөр"-ийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн "чип" багцыг Баруун-Урт сумын 42 өрхөд хүлээлгэн өгсөн юм. Манай байгууллагаас байцаагч Х.Найгуул, Мал хөөгч А.Дорж нар хамрагдсан. Тогны ашиглалтын зардал сард дунджаар 70,80 орчим мянган төгрөг гардаг.



“Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар нь гал тогооныхоо тааз болон ханын засварыг хийж дуусгасан.



Баруун-Урт сумын нийтийн эзэмшлийн зам талбайн улиас моднуудад цэвэрлэгээний огтлол хийж



шинээр тарих 1 наст 10000 ширхэг мөчрийг бэлтгэн авсан.



Өөрсдийн хариуцсан нийтийн эзэмшлийн зам талбайн моднуудад мониторинг хийв.

- Хуучин наадмын талбай
- Өнөр хорооллын урд байрлах ургамлан саад
- 4 болон 5 дугаар тойрог зам дагуух моднууд
 - Төв талбайн хажуугийн ургамлан саад зэрэг газруудад хийсэн.



Дарьганга зочид буудлаас баруун тийш ургамлан хашлагыг дагаж бий болсон хогийг цэвэрлэн хогийн цэгт асгасан.



Баруун-Урт сумын 5 дугаар тойрог зам дагуух модны хамгаалалтын хашааг эвдэж зам гаргасан байсныг засварласан.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

А.ӨЛЗИЙЖАРГАЛ